

ЧИНГИС ХААН ДАХИН МЭНДЛЭХ ҮҮ?

Мацуда Таданори (Япон)

(Английн зохиолч, түүхч Тим Себериний «Чингис хааны эрэлд» (IN SEARCH OF GENGHIS KHAN) номыг зохиолч, орчуулагч Мацуда Таданори япон хэлнээ орчуулсныг «(SANGOKAN)» хэвлэлийн газар хэвлэн гаргалаа. Уг номонд Мацуда Таданорийн бичсэн төсгөлийн үгийг товчлон орчуулж уншигч Танаа толилуулж байна).

«Дэлхийд хамгийн нэртэй Монгол хүн хэн бэ» гэвэл ямар ч хүн түгдрэлгүйгээр «Чингис хаан» хэмээн хариулна биз.

Хүннү, Сүннү, Уйгар, Киргиз монголчууд... Олон зуун жилийн тэртээгээс хойд зүгийн морьтонгууд он удаан жил эргэх хорвоогийн жамаар аугаа их уудам тал нутгийг эзэгнэн суусаар иржээ. 1206 онд Чингис хаан монгол үндэстнийг нэгтгэж ХААН өргөмжлөгдсөнөөр «Талын монголчууд» хэмээх нэр ертөнцийн чихийг дэлсдэг болсон юм. Тэр болтол монголчууд хойт Азийн нүүдэлчдийн нэгээхэн хэсгээс үл хэтрэн тархай бутархай амьдарсаар ирсэн байна. Чингис хаан тэдгээр тархай үндэстнүүдийг өөрийн цэргийн сүр сүлдэн дор нэгтгэж «Монгол үндэстэн»-ийг бий болгожээ.

Үндэстнийг нэгтгэж Монголын Их Гүрнийг байгуулж өгснөөрөө Чингис хаан нь монголчуудын хувьд «үндэсний баатар» билээ. Гэтэл тун саяхан болтол монголчуудын дунд Чингис хааны гавъяа үгүйсгэгдэж, их хаантны нэрийг хүртэл дуудах нь хориотой байв.

«Европ Азийн цэрэг эрсийг Чингис хаан болон түүний үе залгамжлагчидтай харьцуулбал өөдтэй этгээд биш юм» Неру. «Чингис хаан болон түүний үе залгамжлагчидтай харь бүхий л газар нутгийг үнсэн товрог болгож, баян тансаг газар хот сууринийг эвдэж сүйтгэсэн (Маркс).

Ази Европын хүмүүс иймхэн л үнэлэлт дүгнэлтийг өгчээ. Гэтэл Чингис хааныг үнэлэх үнэлгээ цагийн эрхээр өөрчлөгдөв.

ЗХУ-ын тусламж нөлөөгөөр ялсан 1921 оны Ардын хувьсгалын үед ч гэсэн Чингис хаан улсын сүр сүлд хэвээрээ байлаа. 1949 онд Хятадад хувьсгал гарангуутаа монголчуудын үндэсний ухамсар сэргэхээс болгоомжилсон Сталин, Чингис хааныг дахиад л «эсэргүү, сүйтгэгч» болгон будлиантуулав. Орост одоо ч гэсэн «татарын (монголын) дарлал» хэмээх үг бий. Монголын дарлалаас болж Оросын хөгжил илт хохирсон гэж Сталин улайран зүтгэсэн юм.

1962 он монголын сэхээтнүүдийн хувьд яавч мартаж үл чадах гутамшигтай жил байв. Тэр жил ЗХУКН-ын 22-р их хурал хуралдаж Сталиныг дахин хурцаар шүүмжлэх боломж бүрдэж ингэсний үр дүнд «дулаарлын үе» бий болсон юм. Энэ нь монголд ч нөлөөгөө өгч билээ. Ялангуяа хэлмэгдэлд өртсөн үй олон сэхээтэн улс төрийн зүтгэлтнүүд нэр төрөө сэргээж эхлэв. Тухайн оны 2 сард «Чингис хааны 800 жилийн ойг тэм-

дэглэх тухай» МАХН-ын Төв Хорооны тогтоол гарлаа. Удалгүй 5 сарын 31-нд 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал болж ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал Ш. Нацагдорж, Хэл зохиолын хүрээлэнгийн захирал нэрт эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэн нар үг хэлж мэдээлэл хийжээ. Ялангуяа Дамдинсүрэн гуай Оросын зохиолч Ян Кимийн бичсэн «Чингис хаан» хэмээх түүхэн романыг «Орос зохиолч зориудаар мушгин гуйвуулж Чингис хааны дүрийг зохиомлоор бүтээсэн» гэж нэр заан шүүмжилсэн байна. Гэтэл 9 сар гараад Хрушев Цэдэнбалаас «танай улсад үндэсний үзэлтнүүд төрж байна гэж сонслоо. Үнэн гэж үү» гэж асуусан юм гэдэг. Үүний дараахан 800 жилийн ойг тэмдэглэх ажлыг удирдан толгойлж байсан Төмөр—Очир намын эсрэг этгээд гэгдэж НТХ-ны улс төрийн товчоо, нарийн бичгийн даргын ажлаас халагдаж хөдөө цөлөгдсөн юм. Энэ үеэс Ш. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн зэрэг олон эрдэмтэн сэхээтнүүд аргагүйн эрхэнд орсон хэргээсээ хөндийрэхэд хүрчээ.

Энэ хэрэг явдлаас хойш Үндэсний баатар Чингис хаан монголчуудын зүрх сэтгэлд удаан гээчийн шингэн, жаргаж, монголчууд их хаантныг дахин мандан гарч ирэхийг хүлээх хэрэгтэй болсон. Энэ цаг үе Горбачёвын «перестройка» мэндэлснээр олдсон юм...

ЗХУ-ын дэмжлэгээр эрх чөлөөгөө олсон Монгол нь дэлхийд хоёр дахь социалист орон болж оршсоор 70-н жил болж байж саяхан социализмаас татгалзлаа. Ингэснээр өнөөх үндэсний баатар Чингис хаан дахин мэндэлж монголчуудын үндэсний ухамсар хүчтэй сэргэж билээ.

Горбачёвын «перестройка» нь монголын хээр тал нутгаар «чөлөөтэй салхи» болон нисэн ирж олон жилийн бугшсан хар үүлийг хийсгэн хөөсөн юм. 1989 оны сүүлчээс оюутан залуучууд голлон оролцсон Ардчилсан Хөдөлгөөн өрнөв. Яг энэ үед «Хонх» рок хамтлаг нэрий нь хэлэхээс цээрлэж ирсэн Чингис хаандаа хар буруу санаж төөрөлдөж ирснийгээ ойлгож «Өршөөгөөрэй» хэмээх дууг зориулж дуулсан нь ард олны сэтгэлийг ихэд хөдөлгөөд зогсохгүй он удаан жил сэтгэлдээ тээж ирсэн их баатар нь монголчуудын дунд чөлөөтэй амьдрах боломжийг бүрдүүлсэн болно.

Монголд анх удаа Чингис хааны кино хийгдсэн нь ардчиллын ач буян, дулаан салхины бүлээн уур амьсгал байв. Энэ киноны зохиолыг бичилцсэн С. Эрдэнэ гуай «Чингис хаан нь өвөрмөц онцгой хүн биш жирийн нэг монгол хүн байсан гэдгийг л хэлэх гэсэн юм» гэж байхад уг киноны найруулагч Балжинням «энэ киногоор Ардчиллын дараа Монгол улс дахин төрсөн гэдгийг үзүүлэх гэсэн юм» хэмээн ярьцгаасан юм.

1940-өөд оноос Чингис хааны үед хэрэглэж байсан монгол бичгийг хориглож Орос бичигт албадан оруулсан. Харин одоо хагас зуун жилийн дараа тэрхүү монгол бичгээ дахин сэргээж хэрэглэх гэж байна. Энэ бол монголын ард түмний орост булаалгасан үндэсний өвөрмөц онцлогоо эргүүлэн авах гэсэн анхны алхам мөн гэж хэлэхэд буруудахгүй байх. Үүний түшиг тулгуур нь Чингис хаан гэдэг нь маргаангүй. Тиймээс Чингис хаан нь монголчуудын хувьд бэлэг тэмдэг болоод зогсохгүй БУРХАН билээ.

Миний чадан ядан хөрвүүлсэн энэхүү «Чингис хааны эрэлд» ном нь Чингис хааныг дахин төрүүлсэн юм. Хамгийн аятайхан цаг үед бичигдсэн гэж хэлж болно.

Адал явдалт зохиол бичдэг Тим Себерин Монголын хязгаар нутгаар морин аялал хийжээ. Ингэж аялах зуур ардчиллын салхитай цуг сэргэн мандсан нутаг бүрийн онцлогтой буддын шашинтай учирч, бүргэд шувуу, бөө эмгэнтэй тааралдаж, урт хугацаанд цөөхөн төрлийн хоолыг залхтлаа идэж явжээ. Тиймээ, Себериний хувьд энэ бүхэн Чингис хаан хэмээх ертөнцийн нэгээхэн хэсэг байсан болов уу.

70 гаруй жил марксист удирдлаган дор явсаар ирсэн ч Монгол нь жинхэнэ монгол яс чанараа бас ч алдсангүй. Себериний хэлсэнчлэн Оросын хотуудаас онцын ялгарах юмгүй Улаанбаатар хотоос өөр газруудаар явбал Чингис хааны мөрийг олж, монголын ер бишийн ертөнцтэй танилцах боломж бий.

Тэрээр Хангай нутгийн зуны сайхан улирлыг туулангаа Монголын эзэнт гүрэн чухам яагаад задарсныг бодож дүгнэхийг оролдсон байна.

1991 оны намар Себеринтэй Саппород анх нүүр учирч уулзсан юм. Тэр үед Себерин ирэх долоо хоногт Англид хэвлэгдэн гарах гэж байна хэмээн үзүүлсэн энэ номны эх бичмэлийг авч уншаад монгол хэл огт мэдэхгүй мөртлөө монголын тухай гүнзгий ойлголт өвөртөлж явааг мэдээд гайхаж билээ. Тэр «Монгол улс нь Хятадын нөлөөнд ороогүй нь туйлын зөв боллоо» гэсэн дүгнэлтийг энэ номондоо хийсэн нь миний орчуульа гэж бодсон гол учир шалтгаан болсон юм.

Ер нь ЗХУ-аас Монголын дотоод хэрэгт оролцсоор ирсэн нь хичнээн их аймшигтай үр дагаврыг үлдээсэн ч гэсэн ЗХУ-ын удирдлагыг бүхэлд нь үгүйсгэж болмооргүй юм шиг санагдана. Себериний энэ номонд монголчуудын 90 хувь халдварт тэмбүү өвчтэй байсан нь ЗХУ-ын тус дэмжлэгээр устаж үгүй болсон гэжээ.

Хувьсгалын өмнө хүн ам 700 мянга хүрэхтэй үгүйтэй байсан бөгөөд хүн амын хорогдол ихэсч аюулын ирмэг дээр байлаа. Тэмбүү өвчин нь Манж Чин улсаас явуулж ирсэн улс төрийн бодлоготой холбоотой гэдэг яриа ортой ч байж магад. Мөн хувьсгалын дараахан буюу 1929 оны үед эрчүүдийн ердөө 9 хувь нь уншиж бичдэг байсан бол өнөөдөр бичиг үсэг үл мэдэгч бараг үгүй болжээ. Боловсролын энэ өндөр түвшин нь өнөөгийн хүнд бэрхшээлийг давж туулахад томоохон үүрэг гүйцэтгэхээс гадна монголчуудын ирээдүйд итгэх итгэлийн гол үндэс болж байгаа мэт.

«Яршигтай «ЗХУ байгаагүйсэн бол өнөөгийн Монгол яг л Төвд шиг байх байсан. Хятад Төвдөд явуулж буй улс төрийн бодлогоо Монголд мөн л хэрэгжүүлэх байсан биз. Хятад биш Орос нь монголыг жолоодсоноор Монгол хэмээх ертөнц нэг хэсэгтээ оросжсон ч гэсэн Монгол улс болж оршин тогтнож Монголчуудад амьсгаа авах цаг зай үлдээсэн юм, (Себерин).

Гэтэл нэг хэсэг хүмүүс Оросын жолоодлогыг туйлшран үгүйсгэсээр ирсэн. Хятадын доторх Өвөрмонголын Өөртөө Засах оронд амьдарч буй монголчуудын байдлыг хараад би ч гэсэн Себериний дүгнэлтийг буруушааж үл чаднам.

Нэгэн Өвөрмонгол залуу надад ингэж ярьсан удаатай. «Хэдийгээр монголчууд хэд хэдэн оронд харъяалагдан хуваагдмал байдалтай амьдарч байгаа ч гэсэн тухайлбал би Хятадын газар нутагт амьдарч буйч гэсэн Монгол хэмээх тусгаар улс байна гэдэг нь бидэнд сэтгэлийн том хүч дэм болж Монгол гэсэн бахарлыг ямагт төрүүлж байдаг. Сталины талаарх шүүмжлэл байх л юм. Сталин чинь харин монголын тусгаар тогтнолыг хадгалж үлдээсэн биш үү. Жишээлбэл Оросын нөлөөнд байсан боловч НҮБ-д элсэж тусгаар тогтносон улс болохоо хүлээн зөвшөөрүүлсэн. Монгол улс бие даан оршсоор байна шүү дээ. Энэ нь «өвөр» монголчууд бидэнд хичнээн их сэтгэл санааны тэнхээ хайрладаг гэж санана. Үүнийг «гадаад» монголчууд нэг их ойлгохгүй байхаа даа»

Надтай хөөрөлдөж суухдаа тэр залуу «Гадаад дотоод хоёр монголын нэгдэж нийлэх нь бүтэшгүй зүйл» гэж их гутрангаар хэллээ. Нарийн төвөгтэй асуудал юм даа.

Оросын дотор ч гэсэн монгол гарлын буриад, халимаг зэрэг хэд хэдэн автономит улсууд бий.

1992 оны үндсэн хуулиар Монгол улс марксизм—ленинизмээс татгалзлаа. БНМАУ-аас Монгол улс болов. Одоо монгол орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засаг руу орох шилжилтийн үед байна. Нийгмийн амьдралд тогтворгүй байдал үүсэж эдийн засгийн гүн хямралтай цаг үеийг туулж явна. Хэт яаравчилсан зах зээлжүүлэлт ард түмний 25 хувийг ядууралд орууллаа. Яг энэ цаг үед Чингис хаан дахин гарч ирж улс орныг аваад явна гэж найдаж суухаас, мөн монгол хүн бүх их хаантнаа сэтгэл зүрхэндээ тээж, Чингис хаантайгаа цуг ирээдүй рүүгээ итгэл төгс алхахаас өөр замгүй.

Себериний магтан биширсэн монголын аугаа их байгаль нь ч 13-р зууны Чингис хааны үеийнхээс өөрчлөгдөөгүй. Тэрхүү онгон байгальтай цуг он цагийг ардаа орхиж буй нүүдэлчид Себериний харснаар эрүүл чийрэг энх тунх байгаад зогсохгүй монголын ирээдүйн итгэл найдвар болох юм...

«MONGOL TIMES» 1995.№5(29)